

БАТЛАВ:

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Г.ТЭМҮҮЛЭН

**“МАЛЧНЫ ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ”
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндсэн, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Мөн Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Үндсэн аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1.2.-т “Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх...”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд “Зорилт 3.1.Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхуйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” мөн 3.1.1-т “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ.”, 3.1.3-т “Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.” гэж тус тус заасан. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг батлан, 2021 онд орсон өөрчлөлтөөр уг хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн байна.

1.2.Практик, шаардлага

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг 2021 онд өөрчлөлт оруулж 2022 оны 01 дүгээр 01-ний өдөр хүртэл хугацааг сунгасан. Гэвч хуулийн зорилтод бүлэг бүрэн хамрагдах боломжгүй байсан. Уг шалтгаанд дараах нөхцөл байдал нөлөөлсөн. Үүнд:

- Цар тахлын нөлөөлөл буураагүй бөгөөд түүний үр дагаврыг арилах хүртэл Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль 2022 оны 12 дугаар 31-ний хүртэл хүчин төгөлдөр үйлчилсэн. Үүнтэй уялдуулан төрийн байгууллагын зүгээс тодорхой хязгаарлалтууд тогтоож хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд үзүүлэх сөрөг нөлөөлөл үргэлжилсэн.

- Үндэсний статистикийн хорооны даргын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/71 тоот тушаалаар баталсан “Хэрэглээний үнийн индекс тооцох аргачлал”-ын дагуу гарсан үзүүлэлтээр авч үзвэл. Хэрэглээний үнийн улсын индексийн үзүүлэлтээр инфляцын түвшин 2020 онд 2.3 хувь, 2021 онд 13.8 хувь, 2022 онд 13.2 хувь байсан бөгөөд инфляцын түвшин буураагүй.
- Малын зүй бус хорогдлын хувьд Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны 11 дүгээр сарын 07 -ны өдрийн А/188 тоот тушаалын I хавсралт “Хөдөө аж ахуйн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу хийгдсэн судалгаанаас авч үзвэл. 2019 онд 1,117.58 толгой мал, 2022 онд 2,064.07 толгой мал, 2022 онд 3,012.33 толгой мал тус тус хорогдсон байна.
- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас “Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд хариу үзүүлэх бэлэн байдлыг нэмэгдүүлэх нь” хамтарсан хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгааны¹ дүгнэлтээр манай улсын малчин өрхийн гамшгийн эрсдэл даах чадавхын дундаж түвшин 40.45 индекс оноотой байна. Эрсдэл даах чадвар муу өрхүүд хөрөнгө, боломж хязгаарлагдмал тул өвлийн бэлтгэлээ сайн базаах чадамжгүй, нэг удаагийн байгалийн цочир үзэгдэлд малаа алдаж, ядуурлын доод шугам руу буух эрсдэлтэй байна. Судалгаанд хамрагдсан 21 аймгийн 330 сумын 10,023 малчин өрхийн амьжиргаанд сүүлийн 12 сарын хугацаанд хамгийн их нөлөөлсөн цочрол нь Ковид-19 цар тахал (75.6 хувь), дараа нь ган/зуд (48 хувь), энэ хоёр цочролоос үүдэлтэй мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, өвс тэжээлийн үнийн хэлбэлзэл (37.2 хувь) байжээ.

Иймд уг нөхцөл байдлыг харгалзан үзэж Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл боловсруулах шаардлага үүссэн.

Хоёр. Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан анхдагч хуулийн төсөл боловсруулна. Хуулийн төсөл 8 зүйлтэй байна. 1 дүгээр зүйлд Хуулийн зорилт, 2 дугаар зүйлд Хууль тогтоомжийн хамрах хүрээ, 3 дугаар зүйлд Хуулийн нэр томъёоны тодорхойлолт, 4 дүгээр зүйлд Хуулийн үйлчлэх хамрах хүрээ, 5 дугаар зүйлд Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх хувь хэмжээ, 6 дугаар зүйлд Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх, 7 дугаар зүйл Бүрдүүлэх баримт бичиг, 8 дугаар зүйлд Хуулийг дагаж мөрдөх хугацааг тусгана. Мөн дагалдах хуулийн төсөл боловсруулна.

Гурав. Хууль батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний санал

¹ Малчин өрхийн гамшгийн эрсдэл даах чадварын судалгаа

Хуулийн төсөл баталснаар Монгол Улсын төрийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, цар тахлын нөлөөллийн онцгой нөхцөл байдлаас хамаарч малчны тэтгэврийн даатгалын шимтгэлээ төлж чадаагүй малчдын Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхээ эдэлж тэтгэврийн даатгалын шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх боломж бүрдэж, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах болзол, нөхцөл бүрэлдэх юм.

Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль батлагдсанаар малчин нийгмийн даатгалын санд хуулийн төсөлд заасны дагуу тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлөлт хийх бөгөөд нэмэлт ажлын байр бий болгохгүй, захиргааны ачаалал, зардал гарахгүй. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтад заасан хууль тогтоомжийн хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлын тооцоо хийх шаардлагагүй болно.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох хуулийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцэх бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна. Түүнчлэн Малчны тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэхтэй холбоотой харилцааг журмаар зохицуулна.

—oOo—

МАЛЧНЫ ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийн нөхөн төлүүлэх тухай хуулийн гол зорилго нь нийгмийн даатгалын санд хуульд заасны дагуу төлөх ёстой байсан тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх нөхцөлийг бүрдүүлэх бөгөөд алданги, хүү, торгууль тооцохгүй байх зохицуулалтыг агуулж байгаа болно. Уг тэтгэврийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан итгэлцүүрийн дагуу нөхөн төлүүлнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” Мөн Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Үндсэн аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1.2.-т “Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх...”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд “Зорилт 3.1.Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” мөн 3.1.1-т “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ.”, 3.1.3-т “Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.” гэж тус тус заасан. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг батлан, 2021 онд орсон өөрчлөлтөөр уг хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн.

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг 2021 онд өөрчлөлт оруулж 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацааг сунгасан. Гэвч хуулийн зорилтод бүлэг бүрэн хамрагдах боломжгүй байсан. Уг шалтгаанд дараах нөхцөл байдал нөлөөлсөн. Үүнд:

- Цар тахлын нөлөөлөл буураагүй бөгөөд түүний үр дагаврыг арилах хүртэл Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль 2022 оны 12 дугаар 31-ний хүртэл хүчин төгөлдөр үйлчилсэн. Үүнтэй уялдуулан төрийн байгууллагын зүгээс тодорхой хязгаарлалтууд тогтоож хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд үзүүлэх сөрөг нөлөөлөл үргэлжилсэн.
- Үндэсний статистикийн хорооны даргын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/71 тоот тушаалаар баталсан “Хэрэглээний үнийн индекс тооцох аргачлал”-ын дагуу гарсан үзүүлэлтээр авч үзвэл. Хэрэглээний үнийн улсын индексийн үзүүлэлтээр инфляцын түвшин 2020 онд 2.3 хувь, 2021 онд 13.8 хувь, 2022 онд 13.2 хувь байсан бөгөөд инфляцын түвшин буураагүй.
- Малын зүй бус хорогдлын хувьд Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны 11 дүгээр сарын 07 -ны өдрийн А/188 тоот тушаалын I хавсралт “Хөдөө аж ахуйн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу хийгдсэн

судалгаанаас авч үзвэл. 2019 онд 1,117.58 толгой мал, 2022 онд 2,064.07 толгой мал, 2022 онд 3,012.33 толгой мал тус тус хорогдсон байна.

- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас “Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд хариу үзүүлэх бэлэн байдлыг нэмэгдүүлэх нь” хамтарсан хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгааны¹ дүгнэлтээр манай улсын малчин өрхийн гамшгийн эрсдэл даах чадавхын дундаж түвшин 40.45 индекс оноотой байна. Эрсдэл даах чадвар муу өрхүүд хөрөнгө, боломж хязгаарлагдмал тул өвлийн бэлтгэлээ сайн базаах чадамжгүй, нэг удаагийн байгалийн цочир үзэгдэлд малаа алдаж, ядуурлын доод шугам руу буух эрсдэлтэй байна. Судалгаанд хамрагдсан 21 аймгийн 330 сумын 10,023 малчин өрхийн амьжиргаанд сүүлийн 12 сарын хугацаанд хамгийн их нөлөөлсөн цочрол нь Ковид-19 цар тахал (75.6 хувь), дараа нь ган/зуд (48 хувь), энэ хоёр цочролоос үүдэлтэй мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, өвс тэжээлийн үнийн хэлбэлзэл (37.2 хувь) байжээ.

Иймд уг нөхцөл байдлыг харгалзан үзэж Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл боловсруулах шаардлага үүссэн.

Хуулийн төсөл баталснаар Монгол Улсын төрийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, онцгой нөхцөл байдлаас хамаарч малчны тэтгэврийн даатгалын шимтгэлээ төлж чадаагүй малчдын Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхээ эдэлж тэтгэврийн даатгалын шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх боломж бүрдэж, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах болзол, нөхцөл бүрэлдэх юм.

Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль батлагдсанаар малчин нийгмийн даатгалын санд хуулийн төсөлд заасны дагуу тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлөлт хийх бөгөөд нэмэлт ажлын байр бий болгохгүй, захиргааны ачаалал, зардал гарахгүй.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцэх бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна. Түүнчлэн Малчны тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэхтэй холбоотой харилцааг журмаар зохицуулна.

—oOo—

¹ Малчин өрхийн гамшгийн эрсдэл даах чадварын судалгаа

МАЛЧНЫ ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийн нөхөн төлүүлэх тухай хуулийн гол зорилго нь нийгмийн даатгалын санд хуульд заасны дагуу төлөх ёстой байсан тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх нөхцөлийг бүрдүүлэх бөгөөд алданги, хүү, торгууль тооцохгүй байх зохицуулалтыг агуулж байгаа болно. Уг тэтгэврийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан итгэлцүүрийн дагуу нөхөн төлүүлнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Мөн Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Үндсэн аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1.2.-т “Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх...”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд “Зорилт 3.1.Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” мөн 3.1.1-т “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ.”, 3.1.3-т “Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.” гэж тус тус заасан. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг батлан, 2021 онд орсон өөрчлөлтөөр уг хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн.

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг 2021 онд өөрчлөлт оруулж 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацааг сунгасан. Гэвч хуулийн зорилтод бүлэг бүрэн хамрагдах боломжгүй байсан. Уг шалтгаанд дараах нөхцөл байдал нөлөөлсөн. Үүнд:

- Цар тахлын нөлөөлөл буураагүй бөгөөд түүний үр дагаврыг арилах хүртэл Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль 2022 оны 12 дугаар 31-ний хүртэл хүчин төгөлдөр үйлчилсэн. Үүнтэй уялдуулан төрийн байгууллагын зүгээс тодорхой хязгаарлалтууд тогтоож хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд үзүүлэх сөрөг нөлөөлөл үргэлжилсэн.
- Үндэсний статистикийн хорооны даргын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/71 тоот тушаалаар баталсан “Хэрэглээний үнийн индекс тооцох аргачлал”-ын дагуу гарсан үзүүлэлтээр авч үзвэл. Хэрэглээний үнийн улсын индексийн үзүүлэлтээр инфляцын түвшин 2020 онд 2.3 хувь, 2021 онд 13.8 хувь, 2022 онд 13.2 хувь байсан бөгөөд инфляцын түвшин буураагүй.
- Малын зүй бус хорогдлын хувьд Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны 11 дүгээр сарын 07 -ны өдрийн А/188 тоот тушаалын I хавсралт “Хөдөө аж ахуйн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу хийгдсэн судалгаанаас авч үзвэл. 2019 онд 1,117.58 толгой мал, 2022 онд 2,064.07 толгой мал, 2022 онд 3,012.33 толгой мал тус тус хорогдсон байна.

- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас “Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд хариу үзүүлэх бэлэн байдлыг нэмэгдүүлэх нь” хамтарсан хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгааны¹ дүгнэлтээр манай улсын малчин өрхийн гамшгийн эрсдэл даах чадавхын дундаж түвшин 40.45 индекс оноотой байна. Эрсдэл даах чадвар муу өрхүүд хөрөнгө, боломж хязгаарлагдмал тул өвлийн бэлтгэлээ сайн базаах чадамжгүй, нэг удаагийн байгалийн цочир үзэгдэлд малаа алдаж, ядуурлын доод шугам руу буух эрсдэлтэй байна. Судалгаанд хамрагдсан 21 аймгийн 330 сумын 10,023 малчин өрхийн амьжиргаанд сүүлийн 12 сарын хугацаанд хамгийн их нөлөөлсөн цочрол нь Ковид-19 цар тахал (75.6 хувь), дараа нь ган/зуд (48 хувь), энэ хоёр цочролоос үүдэлтэй мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, өвс тэжээлийн үнийн хэлбэлзэл (37.2 хувь) байжээ.

Иймд уг нөхцөл байдлыг харгалзан үзэж Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл боловсруулах шаардлага үүссэн.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан анхдагч хуулийн төсөл боловсруулна. Хуулийн төсөл 8 зүйлтэй байна. 1 дүгээр зүйлд Хуулийн зорилт, 2 дугаар зүйлд Хууль тогтоомжийн хамрах хүрээ, 3 дугаар зүйлд Хуулийн нэр томъёоны тодорхойлолт, 4 дүгээр зүйлд Хуулийн үйлчлэх хамрах хүрээ, 5 дугаар зүйлд Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх хувь хэмжээ, 6 дугаар зүйлд Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх, 7 дугаар зүйлд Бүрдүүлэх баримт бичиг, 8 дугаар зүйлд хуулийг дагаж мөрдөх хугацааг тусгана.

Хуулийн төсөл баталснаар Монгол Улсын төрийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, онцгой нөхцөл байдлаас хамаарч малчны тэтгэврийн даатгалын шимтгэлээ төлж чадаагүй малчдын Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхээ эдэлж тэтгэврийн даатгалын шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх боломж бүрдэж, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах болзол, нөхцөл бүрэлдэх юм.

Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль батлагдсанаар малчин нийгмийн даатгалын санд хуулийн төсөлд заасны дагуу тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлөлт хийх бөгөөд нэмэлт ажлын байр бий болгохгүй, захиргааны ачаалал, зардал гарахгүй.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцэх бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна. Түүнчлэн Малчны тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэхтэй холбоотой харилцааг журмаар зохицуулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна. Хуулийн төсөл 3 зүйлтэй байна. 1 дүгээр зүйлд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт “24.1.6.Малчны тухай хуульд заасан бол.” гэж нэмэх, 2 дугаар зүйлд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.5 дахь заалтын “.” гэснийг “;” гэж өөрчлөх, 3 дугаар зүйлд хуулийг дагаж мөрдөх хугацааг тусгана.

—oOo—

¹ Малчин өрхийн гамшгийн эрсдэл даах чадварын судалгаа